



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 07 дугаар сарын 03 өдөр Дугаар 40

Хэрлэн сум

XXXIX ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 40 дүгээр хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 88,9 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгев.

СОНССОН НЬ:

1. Улсын Онцгой комиссын 2020 оны 25 дугаар хурлын 4.1 дэх заалтын дагуу зарим олон нийтийн үйлчилгээг үе шаттайгаар нээх эсэх талаар хэлэлцэх:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

2. Дотоодын хүмүүнлэгийн тусlamжийн зарцуулалт, саналыг танилцуулах:

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах

3. Эрээнцав боомтын галт тэрэгний ариутгалын төхөөрөмжийг хүлээн авсан ажлын хэсгийн дүгнэлт танилцуулах:

Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын
гишүүн О.Пүрэв-Очир,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Стандарт хэмжил зүйн хэлтэсийн дарга Н.Энхболд нарт:

1.1. Мэргэжлийн байгууллагуудын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилж РС тоглоомын газар, диско болон бүжгийн баарнаас бусад бүх төрлийн хүүхдийн

тоглоомын газар, баар, биллярд, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагаанд стандарт, шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж үйл ажиллаагааг эхлүүлэх зөвшөөрөл олгохыг,

1.2. Эрүүл мэндийн байгууллагаас дээрх ажлын хэсгийг ахлаж халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэх зөвлөмж өгч хяналт тавьж ажиллахыг,

1.3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын үйл ажиллагааг Улсын Онцгой комиссын 2020 оны 25 дугаар хурлын шийдвэрийн дагуу 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдрийг дуустал заагдсан түр хязгаарлалтыг хэвээр үргэлжлүүлэхийг,

Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын
гишүүн О.Пүрэв-Очир,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

1.3. Чойбалсан хотод үйл ажиллагаагаа явуулдаг тоглоомын газар, баар, биллярд, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагаанд стандарт, шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн үе шаттайгаар нээхийг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

1.4. Баарны үйл ажиллагааг нээсэн тохиолдолд ажиллах цагийн хуваарийг 10:00 цагаас 00:00 цаг хүртэл ажиллуулж хяналт тавьж ажиллахыг,

Сумдын Засаг дарга нарт:

1.5. Хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор жагсаал цуглаан, нийтийг хамарсан спортын үйл ажиллагаа, РС тоглоомын газар, диско болон бүжгийн баарнаас бусад бүх төрлийн хүүхдийн тоглоомын газар, баар, биллярд, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагааг халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн үе шаттайгаар нээхийг,

Хоёр. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой
комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д

2.1. Коронавирусын халдварт гарсантай холбоотой 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 03 дугаар сарын 03-ны өдрүүдэд автозамын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэсэн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Автотээврийн төвийн нийт 129 албан хаагч нарийн албан томилолтын зардал 3,012,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусlamжаас олгохыг,

Гурав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:


3.1. Эрээнцав боомтын галт тэрэгний ариутгалын төхөөрөмжийг хүлээн авахад өгсөн 12 заалт бүхий үүргийн биелэлт, мэдээллийг аймгийн Онцгой комиссын 41 дүгээр хуралд танилцуулахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

3.2. Эрээнцав боомтын галт тэрэгний машинч нарт ариутгал халдвартгүйтгэл хийгдэж буй нөхцөл байдлын мэдээллийг аймгийн Онцгой комиссын 41 дүгээр хуралд танилцуулахыг,

Дөрөв Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

4.1. Баяр наадмын өдрүүдэд аймгийн Онцгой комиссын гишүүд холбоо барих боломжийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах, албан томилолтоор болон хувийн ажлаар гадагш явах тохиолдолд аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад мэдэгдэж байхыг тус тус үүрэг болгов.



ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ПРОГРАММ,
ТЕХНИК ХАНГАМЖ ХАРИУЦСАН ИНЖЕНЕР,
АХМАД *Ахмад* Э.ГАНЖИГҮҮР